



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/03

Улаан-уул

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хуулиудад өөрчлөлт орсонтой холбоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулан батлуулахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06, 2019 оны 05 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.


ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 03 сарын 10 ны өдөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/03 дугаар тогтоолын хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН



Зөвлөлийн дарга: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Нарийн бичгийн дарга: ИТХ-ын нарийн бичгийн дарга

Гишүүдэд: Сумын Засаг дарга

Тамгын газрын дарга

Хэсгийн төлөөлөгч

Нийгмийн бодлогын ажилтан

Сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн дарга

Цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн дарга

ХАА-н тасгийн дарга

Мал эмнэлгийн тасгийн дарга

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Олон нийтийн цагдаа

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

3 дугаар багийн Засаг дарга

4 дүгээр багийн Засаг дарга

5 дугаар багийн Засаг дарга

6 дугаар багийн Засаг дарга